

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ХЭРЭГЦЭЭТ ХУВЦАС ХЭРЭГСЭЛ  
НИЙЛҮҮЛЭХ ЦАХИМ ТЕНДЕР**

**БХЯ/20240102019**

2024 он

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) .....	1
1. Тендерийн цар хүрээ .....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	1
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ .....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	3
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг .....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт .....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	4
11. Тендерийн иж бүрдэл .....	4
12. Тендерийн жишиг маягтууд .....	5
13. Хувилбарт санал .....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг .....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага .....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт .....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	8
20. Тендерийн валют .....	8
21. Тендер хүчинтэй байх хугацаа .....	8
22. Тендерийн баталгаа .....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх .....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа .....	9
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах .....	10
29. Оролцогчид давуу эрх олгох .....	10
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	10
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох .....	10
32. Тендерийг эрэмбэлэх .....	10
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	11
34. Мэдэгдэл хүргүүлэх .....	11
35. Гүйцэтгэлийн баталгаа .....	11
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах .....	11

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |   |   |
|---|---|
| 1. Тендерийн цар хүрээ                        | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.   |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.  |
| 3. Худалдан авах ажиллагааны тогтоомж         | 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.   |
| 4. Худалдан авах ажиллагааны систем           | 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.  |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс анgid байх | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.   |
| 6. Сонирхогч оролцогч                         | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.  |
|   | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх-ээр зохион байгуулна.   |
|   | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |
|   | 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 <sup>1</sup> , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.   |
|   | 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.  |

- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
  - 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
  - 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
  - 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
  - 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

- |   |   |
|---|---|
| <p><b>8. Нийлүүлэх барааны гарал үүсэл</b></p> <p><b>9. Тендер шалгаруулалтын баримт бичиг</b></p> <p><b>10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах</b></p> <p><b>11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</b></p> | <p>7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.</p> <p>7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.</p> <p>7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.</p> <p>8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.</p> <p><b>Б.АГУУЛГА</b></p> <p>9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;</li> <li>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;</li> <li>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;</li> <li>IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;</li> <li>V Бүлэг. Тендерийн жишиг маягт;</li> <li>VI Бүлэг. Гэрээний нөхцөл.</li> </ul> <p>9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.</p> <p>9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p> <p>10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүснэгтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.</p> <p>10.2. ТШЗ 10.1-д заасан хүснэгтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.</p> <p>10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.</p> <p>11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.</p> <p>11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.</p> |
|---|---|

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

### **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

- |  |  |   |
|--|--|---|
| <p><b>14. Тендерийн маягтууд</b></p> <p><b>15. Хувилбарт санал</b></p> <p><b>16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг</b></p> <p><b>17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</b></p> | <p>жишиг</p> <p></p> <p></p> <p></p> <p></p> | <p>13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</p> <p>13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.</p> <p>13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p> <p>13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.</p> <p>14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.</p> <p>15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.</p> <p>16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.</p> <p>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:</p> <p>16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;</p> <p>16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;</p> <p>16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.</p> <p>16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.</p> <p>17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.</p> <p>17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> |
|--|--|---|

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолтой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 22. Тендерийн валют**
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

- 24. Тендерийн баталгаа**
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
  - 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
  - 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
  - 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
  - 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
  - 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
  - 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
  - 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

<b>27. Тендерийн талаар тодруулга авах</b>	27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
<b>28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх</b>	28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
<b>29. Тендерийг үнэлэх</b>	29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна. 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
<b>30. Арифметик залруулах</b>	30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна. 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
<b>31. Давуу эрх олгох</b>	31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно. 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй. 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
<b>32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</b>	32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
<b>33. Тендерийн харьцуулах тодорхойлох</b>	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
<b>34. Тендерийг эрэмбэлэх</b>	34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

- |   |   |
|---|---|
| <b>35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах</b>    | 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.<br>35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.<br>35.3. ТШЗ-ны 33.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно. |
| <b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>      |   |
| <b>36. Шийдвэр хүргүүлэх</b>                      | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.   |
| <b>37. Гүйцэтгэлийн баталгаа</b>                  | 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.<br>37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.  |
| <b>38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b> | 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.<br>38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.   |

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

<b>ТШЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: Батлан хамгаалах яам, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Засгийн газрын 7 дугаар байр. Дандарын гудамж 51.
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: Батлан хамгаалахын хэрэгцээт хувцас хэрэглэл нийлүүлэх
<b>ТШЗ 1.1</b>	Тендерийн урилгын дугаар <b>БХЯ/20240102019</b>
<b>ТШЗ 1.2</b>	<i>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</i> Багц №1:Аранз Багц №2:Гутал Багц №3:Биеийн тамирын хувцас Багц №4:Бусад хэрэгсэл Багц №5:Хөдөлмөр хамгааллын хувцас Багц №6:Ахуй хэрэгсэл Багц №7:Хамгаалах хэрэглэл Багц №8:Майхан
<b>ТШЗ 1.3</b>	<i>Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:</i>
<b>ТШЗ 1.4</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх:Үгүй
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Зэвсэгт хүчний хөгжлийн сан
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>1,693,874,200.00</b> төгрөг Багц №1: 244,560,000.00 төгрөг Багц №2: 327,995,000.00 төгрөг Багц №3: 285,432,000.00 төгрөг Багц №4: 107,610,000.00 төгрөг Багц №5: 237,077,200.00 төгрөг Багц №6: 153,760,000.00 төгрөг Багц №7: 97,440,000.00 төгрөг Багц №8: 240,000,000.00 төгрөг
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 8.1</b>	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хаяг: Батлан хамгаалах яам, Засгийн газрын 7 дугаар байр. 219 тоот өрөө. Утасны дугаар: Утас: 263263
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл:“ <b>Монгол хэл</b> ”
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: “ <b>Зөвшөөрөхгүй</b> ”
<b>ТШЗ 17</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн хуваарийг маягтын дагуу хийж, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>2. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>3. Нийлүүлэх бүтээгдэхүүний 1,2,3,4,6,7,8 дугаар багцуудад загвар дээжийг ирүүлнэ.</li> <li>4. Тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл ирүүлэх.</li> <li>5. Тендерт ирүүлсэн бичиг баримттай холбоотойгоор холбогдох газруудаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх.</li> </ol>

	<p>6. Тендериин баримт бичигт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг ирүүлнэ.</p> <p>8. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>9. Шүүхийн төрөлжсөн архиваас иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй тодорхойлсон тодорхойлолтын эх хувийг ирүүлнэ. Хэрэв шүүхэд аливаа маргаанд хариуцагчаар оролцож байсан бол нэхэжлэлийн шаардлагыг хангаж, өр төлбөрийг бүрэн барагдуулсан тухай тодорхойлолт, нотлох баримтыг ирүүлэх.</p> <p>10. Харилцагч банк тус бүрээр хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй тодорхойлолтын эх хувийг ирүүлнэ.</p> <p>Цахимаар ирүүлэх файл нь тод гаргацтай, чанарын шаардлага хангасан файл ирүүлэх ба цахим файл нь харагдахгүй, уншигдахгүй, мөн захиалагчаас шаардсан баримт бичгийг дутуу ирүүлсэн тохиолдолд шаардлагад нийцээгүй гэж үзэж, тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТШЗ 17.4</b>	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: <b><u>"Тийм"</u></b> Нийт багцад заасан хүнсний материал хэрэгсэлд дээж ирүүлэх
<b>ТШЗ 17.6</b>	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: <b><u>"Тийм"</u></b>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: <b><u>"Шаардана"</u></b> <b><u>Үг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээлэл ирүүлэх</u></b></p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: <b><u>"Шаардлагатай"</u></b> Санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй хэмжээний ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг сүүлийн 1 жилд дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна.</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: <b><u>"Шаардлагатай"</u></b></p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 1 жил, 2023 оны санхүүгийн тайлан</p> <p><b><u>Борлуулалтын орлогын хэмжээ: ТШЗ-ны 18.3-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 100% хувиас багагүй байх.</u></b></p>
<b>ТШЗ 18.2</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b><u>"Шаардана"</u></b>
<b>ТШЗ 19.1</b>	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b><u>"Тийм"</u></b></p> <p>Санхүүгийн чадавхтай холбоотойгоор хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичиг. Сүүлийн 1 жил, 2023 оны санхүүгийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> <li>- харилцагч банкны мэдэгдэл; зээл авах боломжит хэмжээг тодорхойлтоор ирүүлэх</li> <li>- Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа;</li> <li>- Сүүлийн 1 жил, 2023 онд хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан;</li> <li>- Сүүлийн 1 жил, 2023 онд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</li> </ul>

	<p>-санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт</p> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 1 жил, 2023 онд</p>
<b>ТШЗ 20.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b><u>“Тийм”</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг;</li> <li>- гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл;</li> <li>- оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил тестэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл</li> <li>- бараа нийлүүлэхэд ашиглахаар Өгөгдлийн хүснэгт болон техникийн тодорхойлолтод заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт) бэлэн байлгах санал;</li> <li>- техникийн чадавх болон туршлагын талаар ТШЗ-ны 16.1-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох Өгөгдлийн хүснэгтэд заасан бусад баримт.</li> </ul> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардана”</b></p> <p>Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 6-ын дагуу ирүүлнэ.</p>
<b>ТШЗ 21.5.</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b> гэсэн тодорхойлолт ирүүлэх
<b>ТШЗ 21.6</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ 24.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: Доорхи багцуудад тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож ирүүлнэ</p> <p>Багц №1, Багц №2, Багц №3, Багц №4, Багц №5, Багц №6, Багц №8</p> <p><b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b></p>
<b>ТШЗ 25.5.</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p><b>[Жишээ нь:</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;</b></li> <li><b>2. Санал болгосон бараг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт гэх мэт баримт бичгийг жагсаан бичих]</b></li> </ol>
<b>ТШЗ 26.1.</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024.02.15</b></p> <p>Цаг: <b>10:00</b></p>
<b>ТШЗ 26.2.</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024.02.15</b></p> <p>Цаг: <b>10:30 минут</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>[аймаг/хол, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</b></p> <p><b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b></p>
<b>ТШЗ 29.2.</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>

<b>ТШЗ 31.1.</b>	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: давуу эрх тооцуулах хүсэлт, барааны жагсаалт, давуу эрх тооцуулах эсхийг нотлох бичиг баримт
<b>ТШЗ 32.1</b>	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “ <b>Aшиглахгүй</b> ”

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Д/д	Материалын нэр, төрөл	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ уу.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсргана)
-----	--------------------------	-------------------------------------	--	---

Багц 1: Аранз, цүнх

1	Аранз	Цэргийн зориулалттай Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан бат бөх байна. Бор шаргал өнгийн брезентен материалтай будгийн тогтвортжилт сайн гандаж, ханзарч, урагдахүй, ирмэн оруулга бүхий давхар бэхэлгээнүүдтэй байна. Ус, салхины хамгаалалттай, мөрөвч болон нурууны арын хэсгийн ачааллыг шийдвэрлэсэн, сайн чанарын түгжээ, цахилгаантай байна. Хамгаалалтын сав баглаа боодлойтой байна. Хэмжээ: урт нь 40 см-ээс багагүй, өргөн 35 см-ээс багагүй, өндөр нь 50 см-ээс багагүй. Цүнхний оёдол давхар оёгдсон, 2-3 том тасалгаатай, 30 кг-ын даацтай 30 литрийн багтаамжтай байна.		
2	Том цүнх	Цэргийн зориулалттай Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан бат бөх байна. Бор шаргал өнгийн брезентен материалтай будгийн тогтвортжилт сайн гандаж, ханзарч, урагдахүй, ирмэн оруулга бүхий давхар бэхэлгээнүүдтэй байна. Ус, салхины хамгаалалттай, ачааллыг даах бариул болон сайн чанарын ирмэн оосортой, сайн чанарын түгжээ, цахилгаантай байна. Хамгаалалтын сав баглаа боодлойтой байна. Хэмжээ: урт нь 80 см-ээс багагүй, өргөн 40 см-ээс багагүй, өндөр нь 30 см-ээс багагүй. Цүнхний оёдол давхар оёгдсон, их бие тойрсон 3-4 том халаастай, 80 кг-аас багагүй даацтай, 80 литрээс багагүй багтаамжтай байна.		
3	Аврах хантааз	<p>Уснаас аврах ажиллагааны хувцас, хэрэглэлд тавих шаардлага MNS 6346:2012-ийг хангаж баталгаажуулсан байна. Материалын ус үл нэвтрүүлэлт нь 25,000 мм-ээс багагүй байна.</p> <p>Материалын амьсгалах чадвар нь 24 цагийн туршид 5,000 г/м<sup>2</sup>-аас багагүй байна. Аврах хантаазыг хүний биеийн хэмжээнд тааруулан ихэсгэж, багасгадаг түгжээтэй байна.</p> <p>Хувцас нь бөх бат, эдэлгээний хугацаанд хамгаалах чадвараа найдвартай хадгалах, хадгалалт элэгдэлтэд тэсвэртэй, засварлах боломжтой байна. Хувцас нь аюулгүй байдлыг хангаж усны өнгөнөөс ялгарч харагдах тод өнгөтэй байна.</p> <p>Сургуулийн лого, бичиглэлтэй байх,, Өнгө: Улаан</p>		

Багц 2: Гутал

1	Хагас түрийтэй өвлүүн гутал /хар/	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварын шаардлага хангасан байх. MNS 0078:1980, MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтлана. Гутал нь маш хөнгөн уян нугарамхай, хөлд эвтэйхэн, хальтирч гулгахгүй, эрүүл ахуйн, эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн, хүний биеийг гадны нөлөөллөөс хамгаалж, стандартын шаардлагыг хангасан үхрийн цэвэр арьсаар хийгдсэн байна.		
---	--------------------------------------	--	--	--

		<p><b>Толгой, түрий:</b> Хар өнгийн арьсан/шир/</p> <p><b>Дотор:</b> нэхий, чийг татахгүй, хөлд эвтэйхэн байх.</p> <p><b>Дотуур ул:</b> Хэвэлгээтэй, нум тэмөртэй материалыаар хийгдсэн, чийг шингээх гадагшлуулах чадвар өндөр, хөлийн нумны хэлбэрийг алдагдуулахгүй, гүйж харайхад эвтээхэн байх.</p> <p><b>Ар зуузай:</b> Зориулалтын арьсан зулгатай, чанартай, өсгийн хатуулга: зориулалтын хатуулгатай</p> <p><b>Гадуур Ул:</b> гадуур улыг наалт болон утсан, улалгааг хослуулсан технологиор үйлдвэрлэнэ. Ул нь халтираас хамгаалсан +EVA материалтай, нягт, нугаралтанд уян хатан, арзгар улны температурын хэлбэлзэл 55C+210C тэсвэртэй, цэвэр ширэн улавчтай.</p> <p><b>Утас:</b> Гутлын зориулалтын 3 эрчлээстэй бөх бат</p> <p><b>Цавуу:</b> Т-1 сайн чанарын 9 Бэлэн болох бүтээгдэхүүнд өнгө үзэмж чанар сайдруулах нэмэлт ажиллагаа хийгдсэн байна. 10 Гутал нь хагас түрийтэй, үдээстэй, загварын хэв маяг, гадаад үзэмж, оёдлын чанар байдал, материалын чанар, захиалагч талаас гаргасан шаардлагад нийцсэн байна.</p>		
2	Хагас түрийтэй гутал /цэлийн/	<p>Нэг: Дээд эд ангийн тодорхойлолт</p> <p>1 Толгой, түрий: Шар өнгийн зориулалтын угаах боломжтой арьс /шир/, брезент /шар/ усны хамгаалалттай, даауун дотортой, гутлын шагайн хэсэгт суналтаас хамгаалсан элгэн оруулгатай, үдээсний оруулга нь гууртай, дотрын зориулалтын материал, хэлний хэсэг сайн чанарын брезентэн материалтай, эмжээртэй. арьсан болон зориулалтын ус, чийгийн хамгаалалттай улавчтай.</p> <p>Хоёр: Загварын эд ангийн техникийн тодорхойлолт:</p> <p>Ул: шахмал, кавчук, Дотуур ул: сайдруулсан шахмал цаас, хэвэлгээтэй, чийг шингээх гадагшлуулах чадвар өндөр</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар батлагдсан загварын шаардлага хангасан байх.</p> <p>MNS0078:1988,MNS 6414:2013, MNS 6415:2013 стандартын шаардлагыг баримтлана.</p> <p>Ар зуузай: Зориулалтын арьсан зулгатай, чанартай, өсгийн хатуулга: гарниздкан хатуулгатай</p>		

		<p>Резин ул: гадуур улны зориулалттай, нягт, нугаралтанд уян хатан, хугарахгүй.</p> <p>Утас: Гутлын зориулалтын 3 эрчлээстэй бат, бөх, дотор, ар, давхар суройсон байна.</p> <p>Цавуу: Т-1</p> <p>Бэлэн болох бүтээгдэхүүнд өнгө үзэмж чанар сайжруулах нэмэлт ажиллагаа хийгдсэн байна.</p> 		
3	Ажлын гутал	<p>ISO 20345:2011 стандартын шаардлагыг хангана. Богино түрийтэй үдээстэй, хар гутал.</p> <p>Хамрын хатуулга: Хөлийн хурууны зориулалтын хамгаалалт, халцаархаас хамгаалсан резин</p> <p>Дотор: Зориулалтын доторлогоотой</p> <p>Дотуур ул: Хадаас нэвтрүүлэхгүй, Цахилгаан дамжуулахгүй</p> <p>Үхрийн арьсан, чийгийг гадагшлуулах арьсан гадар</p> <p>Хөлийн нумны зориулалттай</p> <p>Улавч: 6 мм-ээс багагүй эсгий улавч</p> <p>Гадуур ул: 8 мм-ээс багагүй зузаан эсгий + резин</p> <p>Дээрх шаардлага хангасан эсвэл илүү бол шаардлага хангасан гэж үзнэ.</p> 		
Багц:3 Биеийн тамирын хувцас				
1	Биеийн тамирын хувцас	<p>Их бие хар хөх өнгийн DRI-FIT материалтай /амьсгалдаг/, дээд хэсэгтэй цагаан оруулгатай, оруулган дундаа саарал өнгийн хавчуургатай, реглан ханцуйтай, энгэртэй өнгө дагуу цахилгаантай, зүүн энгэрт терийн далбаа 40x80 мм-ийн харьцаатай оёгдсон байна. Цахилгаантай халаастай, ханцуй, хормой хар хөх өнгийн манжеттай, хувцасны ар нуруу хэсэгт "MONGOLIAN</p>		

		<p>ARMED FORCES" гэсэн хар хөх өнгийн сайн чанарын зориулалтын наалтан бичигтэй байна. Өмд нь хар хөх өнгийн DRI-FIT материалтай /амьсгалдаг/, ташааны оёдолдоо саарал өнгийн хавчуургатай, цахилгаантай халаастай, өмдний дээд тал нь резин болон даавуун чангаль урттай, шуумаг манжеттай. Агшиж сунахгүй, агаар нэвтрүүлэх чанар сайн, хөлс гадагшлуулдаг, будаг гарахгүй байх. Утас том, жижиг материалын өнгө дагуу товч, ярлык, туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p> 		
2	Биеийн тамирын шорт	<p>Их бие хар хөх өнгийн DRI-FIT материалтай /амьсгалдаг/, ташааны оёдолдоо саарал өнгийн кантан оёдолтой, дээд тал нь резинтэй, үйлдвэрийн даавуун чангаль урттай, үйлдвэрийн гэмтэл согоггүй, 2 талдаа халаастай байна. Зүүн гуяны доод талын гадар хэсэгт "MONGOLIAN ARMED FORCES"-ийн товчлол "MAF" гэсэн бичиглэлийг цагаан өнгийн сайн чанарын зориулалтын хуулган наалтан бичигтэй. Агшиж сунахгүй, агаар нэвтрүүлэх чанар сайн, хөлс гадагшлуулдаг, будаг гарахгүй байх. Утас том, жижиг материалын өнгө дагуу товч, ярлык, туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p> 		

3	Биеийн тамирын футболка	<p>Их бие цагаан өнгөтэй, реглан ханцуйтай, ханцуй хар хөх өнгөтэй, дугуй цагаан захтай, зүүн энгэрт төрийн далбаа 40x80 мм-ийн харьцаатай оёгдсон байна. Ар нураа хэсэгт “MONGOLIAN ARMED FORCES”-ийн товчлол “MAF” гэсэн бичиглэлийг цэнхэр өнгийн сайн чанарын зориулалтын хуулган наалтаар наасан байна. Агшиж сунахгүй, агаар нэвтрүүлэх чанар сайн, хөлс гадагшлуулдаг, будаг гарахгүй байх. Утас том, жижиг материалын өнгө дагуу ярлык, туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p> 

Багц:4 Бусад хэрэгсэл

1	Үндны усны үүрдэг сав	<p>Олон улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан, үндсэн ба туслах материалууд чанарын шаардлага хангасан бат бөх байна. Хэмжээ 2 л-с багагүй гол, усны хамгаалалттай, бор шаргал өнгийн байна. Үүргэвч цүнхны осор бүч түгжээ зэрэг нь үндсэн материалтай ижил өнгөтэй байна. Дотор талын шингэн агуулах сав нь хүнсний зориулалтын шингэн хадгалах боломжтой эсэх талаар итгэмжлэгдсэн лабораторийн эрүүл ахуйн дүгнэлттэй байх.</p> 
2	Шумуулын хамгаалалтын тор /орны, зээврийн/	<p>Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартыг баримтлах, ахуйн хэрэглээний байх. Хэмжээ: урт 2м, өргөн 1,2 м өндөр 2м хэмжээтэй, хэлбэр нь хайрцаглан оёгдсон, дээд 4 өнцгөөс таазанд бэхлэгдэх зориулалтын гогцоо уяатай /уяа нь 30 см-ээс багагүй/, хормой хэсгээр хумиж чангалах гүйдэг уяатай, торны нүх нь 0,2 мм-с ихгүй, цагаан өнгийн 80 хувийн нейлон утсаар нэхсэн байна. Үндсэн материалд гэмтэл согоггүй байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p>

3	Толгойн шумуулын хамгаалалтын тор	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн материал нь ногоон өнгийн бөх чанартай, гэмтэл согоггүй байна. Гадны хортон, шавьж хорхойноос хамгаалалтын зориулалтаар ашиглагдахаар байна. Торны нух нь 0,2 мм-ээс ихгүй, ногоон өнгийн 80 хувийн нейлон утсаар нэхсэн байна.		
4	Улаан цагаан туз	Силкэн материал байна.		
5	Нүдний шил	Буудагчийн нүдийг хамгаалах, буудлага секторыг хянах, гялбаанаас хамгаалах шар, хар, цагаан өнгийн сольж хэрэглэж болох шилтэй, амархан хугарахгүй уян гартай байна.		
6	Замын тэмдэглэгээ конус			

**Багц 7: Хамгаалах хэрэгсэл**

1	Дуулганы бүрээс	Дуулганы бүрээс нь дижитал эрээн өнгийн, даавуун материалыараар хийгдсэн, дотор талдаа зангуун наалттай, гадна талдаа таних тэмдэг наах зориулалттай зангуу оёгдсон байна.		
2	Өвдөг, тохойны хамгаалалт	Цэргийн тусгай зориулалттай, үндсэн ба туслах материал нь бат бөх Олон улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан хамгаалах хатуулга нь полиэтилен (кевлар) хуванцар материал орсон байна. Өвдгөвч, тохойвч нь дижитал эрээн өнгийн материалыараар бүрсэн, хар өнгийн хамгаалах хатуулгатай, хатууллын ард хар өнгийн материалаар бүрсэн порлонон зөөлөвчтэй байна.		
3	Агсамж	Цэргийн тусгай зориулалттай, үндсэн ба туслах материал нь бат бөх Олон улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан материалтай байна.		
		Бор шаргал өнгийн брезентэн материалтай будгийн тогтвортолт сайн гандаж, ханзарч урагдахгүй ирмэг оруулга бүхий давхар бэхэлгээнүүдтэй байна.		
		Агсамж нь урд талдаа магазин хийх- 4ууттай, гар чийдэн хийх -1 ууттай, автомат буу зүүх зориулалтын тогтоогч (карбин)-той байна.		
		Хөдөлгөөнд саад учруулахгүй, хувцас болон биеэнд гулсдаггүй, хөнгөн, уян хатан, хэмжээ (размер) тааруулах тохиуулагчтай байна.		

**Багц 6: Хөдөлмөр хамгааллын хувцас**

1	Ажлын хувцас	MNS ISO 13688:2000 хөдөлмөр хамгаалалын зориулалтын байна. Ажлын нөхцөлд тохирсон, хийц загварын шинэлэг шийдэлтэй, хүний биеийн хөдөлгөөнд саад болохгүй байх, хувцас өмсөж тайлахад хялбар байх, дулаан хадгалах чадвар, агаар нэвтрүүлэх материалытай байна. Ажлын хувцасны зориулалтын материалыараар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байж болно. Хар хөх өнгөтэй байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалыуд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Үндсэн ба туслах материалыд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд жижиг деталь хэсгүүд ижил өнгөтэй байна. 5-6 товчоор товчлогддог энгэртэй байна. Хормой нь манжеттай байна. Лавсантай утсаар оёно. (утасны давхарлалт-2). Бүх хувцас хэрэглэлийн чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгаастайгаар оёно. Үндсэн материалыд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, широоноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
2	Ажлын бээлий	MNS ISO 13688:2000 стандартын шаардлага хангахийц. Алган талдаа зузаан илгэн материалытай, 5 хуруутай, чанар стандартын шаардлага хангасан, үйлдвэрийн бээлий байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2)		
3	Ахлах тогоочийн малгай	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалыуд нь чанарын шаардлага хангасан, үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав		

		баглаа боодлой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
4	Ээлжийн тогоочийн малгай	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан, үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодлой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
5	Даавуун халад, өмд /тогооч/	Үйлчилгээний ажилчдад зориулсан өмд цамц байна. Өмд цамц нь зориулалтын материалыаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байна. Цагаан цэнхэр, цайвар ногоон өнгүүдтэй байж болно. Энгэр зөрсөн хоёр эгнээ төвчнуудтай орчин үеийн загвартай байна. Бүх хувцас хэрэглээний чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгаштайгаар оёно. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна.		
6	Цээживчтэй хормогч	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Нимгэн даавуун материалытай, урдаа халаастай, хүзүүгээр угладаг болон ардаа уяатай байна. Үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодлой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
7	Бэлтгэгч, үйлчлэгчийн малгай	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан, үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодлой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
8	Богино ханцуйтай даавуун халад, өмд	Зориулалтын материалыаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байна. Цагаан цэнхэр, ногоон өнгөтэй байж болно, цамц нь богино ханцуйтай, индуудлэг авдаг байна. Өмд- баруу биш, цултай өнгийн, резинэн татлагатай байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
9	Даавуун халад	Халадны зориулалтын материалыаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байна. Цагаан өнгөтэй, урт ханцуйтай, ханцуйн манжет нь өөрөөсөө даавуун, баруу биш, энгийн хийцтэй, урт нь өвдөгнөөс доош дөрвөн хуруу, зах бартаа нь эгэмнээс доошгүй цэвэрхэн байх, гэрэлтдэггүй материалытай индуудлэг авдаг байна. Ардаас өмсөгддөг задгай энгэртэй, энгэр нь товчтой байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
10	Хулдаасан хормогч	Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдж буй чанарын шаардлага хангасан. Үндсэн ба туслах		

		материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Нимгэн лидринэн материалтай, урдаа халаастай, хүзүүгээр угладаг болон ардаа уяатай байна. Үйлдвэрийн гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгийн бат бөх чанартай байна. Хамгаалалтын сав баглаа боодлтой байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2) Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		
11	Даавуун нөмрөг	Хөвөн даавуун материалтай, урдаа тогтоох уяатай байна. Урт нь өвдөг хүрэх хэмжээтэй байна.		
12	Зөөгчийн цамц	Хөвөн даавуун материалаар хийгдсэн, урт ханцуутай, урдуураа товчлогддог, цулгуй цагаан өнгийн байна.		
13	Зөөгчийн хантааз	Хар өнгийн даавуу 60 хувь, нейлон 40 хувийн харьцаатай үйлдвэрийн гэмтэл согоггүй, энгэрийн 2 талдаа жижиг халаастай, гурвалжин захтай, урд хэсэг нь 3-4 товчтой байна. Ханцуүгүй, нимгэн дотортой, чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгастайгаар оёно. Хамгаалалтын сав баглаа боодлтой байна.		
14	Зөөгчийн юбка болон эр өмд	Хар өнгийн даавуу 60 хувь, нейлон 40 хувийн харьцаатай үйлдвэрлэлийн гэмтэл согоггүй, юбканы урт өвдөг хүрсэн хэмжээтэй, шулуун загварын байна. Эргэтий өмд нь хар өнгийн шулуун загвартай, залгах захтай, зургаан түдүүлтэй, ташаандaa ташуу халаастай, баруун гүяны арын дээд хэсэгт хагалаа халаастай байна.		
15	Ажлын фудболк	Цагаан өнгийн сүлжмэл даавуун материалтай будгийн тогтвортжилт сайн гандаж агшиж сунахгүй. Даавуу 60 хувь, нейлон 40 хувийн харьцаатай байна. Хамгаалалтын сав баглаа боодлтой байна		
16	Ажлын өмд	Цайвар өнгийн өмд-бариу биш, цулгай өнгийн, резинэн татлагатай байна. Утас, товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан материалтай будгийн тогтвортжилт сайн гандаж агшиж сунахгүй байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй. Хамгаалалтын сав баглаа боодлтой байна.		
17	Засварын ажилчдын хувцас	MNS ISO 13688:2000 хөдөлмөр хамгаалалтын зориулалтын байна. Ажлын нэхцэлд тохирсон, хийц загварын шинэлэг шийдэлтэй, хүний биеийн хөдөлгөөнд саад болохгүй байх, хувцас өмсөж тайлахад хялбар байх, дулаан хадгалах чадвар, агаар нэвтрүүлэх материалтай байна. Ажлын хувцасны зориулалтын материалаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байж болно. Хар хөх өнгөтэй байна. Утас товч, ярлык, дэгээ, гогцоо зэрэг туслах материалууд нь өнгө дагуу, чанарын шаардлага хангасан байна. Үндсэн ба туслах материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд жижиг деталь хэсгүүд ижил өнгөтэй байна. 5-6 товчоор товчлогддог энгэртэй байна. Хормой нь манжеттай байна. Лавсантай утсаар оёно. (Утасны давхарлалт-2). Бүх хувцас хэрэглэлийн чимэг оёдлыг 1см-т 5-6 дотрын ба хавсарч оёсон оёдлыг 1см-т 4-5 хатгаастайгаар оёно. Хамгаалалтын сав баглаа боодлтой байна. Үндсэн материалд үйлдвэрлэлийн болон механик гэмтэл согог байж болохгүй бөгөөд ижил өнгөтэй байна.		
18	Пүүз	Олон улсын чанарын шаардлага хангасан цагаан, цайвар өнгийн, загвар өнгө үзэмж сүүлийн үеийн хэв шинжийг агуулсан гүйлтийн пүүз байна. Гутлын гадна ул, есгий нь сайн чанарын үүсэн материалаар хийгдсэн байна. Халтирахгүй байх. Дотуур ул: чийг шингээх гадагшлуулах чадвар өндөр байх. Бэлэн болох бутээгдэхүүнд өнгө үзэмж чанар сайжруулах нэмэлт ажиллагаа хийгдсэн байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.		



Багц:7 Ахуй хэрэгсэл

Багц:7 Ахуй хэрэгсэл			
1	Цагаан хэрэглэл	<p>Утас, ярлык зэрэг үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан байна. Эрүүл ахуйн талаар итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дун болон Улсын байцаагчийн дүгнэлт, шинжилгээний дүгнэлттэй байна. Ор хөнжлийн даавуу дэрний уутны давхар дарж оёсон оёдол 0.5 см, ирмэгээсээ 0.1 см-т тэгш оёсон байна. Дэрний уутын 60x43 см-ийн хэмжээтэйгээр нэг талдаа 18 см-ийн зэрлэг амтай дотор талаасаа 2 давхар буюу тусгай зориулалтын машинаар оёсон байна. Хөнжлийн даавуу нь 200x145 см, орны даавуу нь 200x118 см хэмжээтэй тэгш оёсон байна. Дээрх хэмжээнд (<math>\pm 2-8</math>) см байна. Ор хөнжлийн даавуу нь цулгүй цагаан, цэцэг хуар, хэт эрээн хээтэйгээс бусад байна. Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p> 	
2	Нимгэн оймс		
3	Ванны алчуур	<p>Өргөн хэрэглээний ус маш сайн шингээдэг ванны алчуур байна. Цагаан шаргал өнгөтэй 100% даавуун байна. Хэмжээ урт 150 см, өргөн 90 см-ээс (<math>\pm 3-5</math> см) багагүй байна. Алчуур өлгөх зориулалтын оосортой байна. Итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дун болон Улсын байцаагчийн дүгнэлт, шинжилгээний дүгнэлт, Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p>	
4	Гарын алчуур	<p>Өргөн хэрэглээний ус маш сайн шингээдэг гарын алчуур байна. Цагаан шаргал өнгөтэй байна. Хэмжээ урт 75 см, өргөн 35 см-ээс (<math>\pm 3-5</math> см) багагүй, цэвэр даавуун, Алчуур өлгөх зориулалтын оосортой байна. Итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дун болон Улсын байцаагчийн дүгнэлт, шинжилгээний дүгнэлт, Тухайн бараанууд нь ус, чийг, тоос, шорооноос хамгаалагдсан савлаж ууталсан байна.</p>	
5	Углааш усны	<p>Углааш /тапочки/ бүтээгдэхүүн шинэхэн үйлдвэрлэгдсэн өргөн хэрэглээний хүний биед ямар нэгэн сөрөг нөлөөгүй сайн чанарын бүтээгдэхүүн байна. Ердийн хэрэглээний үйсэн /каучук/ шахмал хар, хар хөх, цэнхэр өнгийн байна.</p>	

Багц:8 Майхан

		<p><b>Ерөнхий нөхцөл:</b></p> <p>Майхан нь 140 кг/м<sup>2</sup> хүртэл цасны ачаалал тэсвэрлэх, салхины эсэргүүцэл 48 кг/м<sup>2</sup> тэсвэрлэх чадвартай, энэхүү хүрээ нь ган карказ холбоостой, хоёр давхар PVC материалыаар хийгдсэн бүрэн ус үл нэвтрэх дээвэр бүхий хосолсон гадна саравчнаас бүрдэнэ. Гаднах саравчны хана нь байгалийн агааржуулалтыг хангахын материалыаар хийгдсэн байна. Дээвэрт ган хуудсаар хийгдсэн яндангийн хоёр нүх, ханан дээр нь дулааны буу утас холбох ханцуивчтай, дотор нь угааж болдог, цонхнууд нь шумуулын тор зөөврийн пластик дүүргэгчээр тоноглогдсон. Орц нь үүдний танхимтай, -50°C хүртэл хярууг тэсвэрлэнэ.</p> <p>Урт 10м, өргөн 6,7м, хажуугийн хананы өндөр 2,4м, нурууны дагуух өндөр 3,4м-ээс багагүй байна.</p> <p>ОХУ-д үйлдвэрлэгдсэн Палатка М-30 загвартай ерөнхий чанар, үзүүлэлтээр дүйцэхүйц.</p>		
1	Каркастай палатка том	<p><b>ТУСГАЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b></p> <p>Шалавч: Их биетэйгээ холбогддог шалавчтай байх ба асрын доторхыг гэрэлтэй гэгээтэй байх үүднээс цагаан өнгөтэй материалыаар хийнэ.</p> <p>Дөл тэсвэрлэх чадвар: DIN4102 B1/M2</p> <p>Гадаснууд: Сайн чанарын сайжруулсан төмөр материалыаар хийсэн 50 см-ээс багагүй урттай гадас, алхны хамт</p>		
2	Каркастай палатка жижиг	<p><b>Ерөнхий нөхцөл:</b></p> <p>Майхан нь 140 кг/м<sup>2</sup> хүртэл цасны ачаалал тэсвэрлэх, салхины эсэргүүцэл 48 кг/м<sup>2</sup> тэсвэрлэх чадвартай, энэхүү хүрээ нь ган карказ холбоостой, хоёр давхар PVC материалыаар хийгдсэн бүрэн ус үл нэвтрэх дээвэр бүхий хосолсон гадна саравчнаас бүрдэнэ. Гаднах саравчны хана нь байгалийн агааржуулалтыг хангахын материалыаар хийгдсэн байна. Дээвэрт ган хуудсаар хийгдсэн яндангийн хоёр нүх, ханан дээр нь дулааны буу утас холбох ханцуивчтай, дотор нь угааж болдог, цонхнууд нь шумуулын тор зөөврийн пластик дүүргэгчээр тоноглогдсон. Орц нь үүдний танхимтай, -50°C хүртэл хярууг тэсвэрлэнэ.</p> <p>Урт 6,1м, өргөн 4,8м, хажуугийн хананы өндөр 1,7м, нурууны дагуух өндөр 2,4м-ээс багагүй байна.</p> <p>ОХУ-д үйлдвэрлэгдсэн Палатка М-10 загвартай ерөнхий чанар, үзүүлэлтээр дүйцэхүйц.</p> <p><b>ТУСГАЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b></p> <p>Шалавч: Их биетэйгээ холбогддог шалавчтай байх ба асрын доторхыг гэрэлтэй гэгээтэй байх үүднээс цагаан өнгөтэй материалыаар хийнэ.</p> <p>Дөл тэсвэрлэх чадвар: DIN4102 B1/M2</p> <p>Гадаснууд: Сайн чанарын сайжруулсан төмөр материалыаар хийсэн 50 см-ээс багагүй урттай гадас, алхны хамт</p>		

## Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, төндөрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Төндөрт оролцогч энэ баганыг бөглөнө)
Багц 1: Аранз						
1	Аранз	ш	900	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	
2	Том цүнх	ш	900			
3	Аврах хантааз	ш	12			
Багц 2: Гутал						
1	Хагас түрийтэй өвлийн гутал /хар/	хос	38	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	
2	Хагас түрийтэй гутал /цөлийн/	хос	1750			
3	Ажлын гутал	хос	35			
Багц 3: Биеийн тамирын хувцас						
1	Биеийн тамирын хувцас	хос	1138	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	
2	Биеийн тамирын шорт	ш	888			
3	Биеийн тамирын футболка	ш	888			
Багц 4: Бусад хэрэгсэл						
1	Толгойн шумуулын хамгаалалтын тор	ш	850	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	
2	Үндны усны үүрдэг сав	ш	850			
3	Шумуулын хамгаалалтын тор /орны, зөөврийн/	ш	850			
4	Улаан цагаан тууз	ш	2			
5	Нүдний шил	ш	35			
6	Замын тэмдэглэгээ конус	ш	5			

	Шүүгчид, баг тамирчдын ханцуйн таних тэмдэг	ш	75		
	Ханцуйн тэмдэг	ш	670		

Багц 5: Хөдөлмөр хамгааллын хувцас

1	Ажлын хувцас	хос	275	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд
2	Ажлын бээлий	хос	2690		
3	Ахлах тогоочийн малгай	ш	20		
4	Ээлжийн тогоочийн малгай	ш	110		
5	Даавуун халад, өмд /тогооч/	хос	107		
6	Цээживчтэй хормогч	ш	113		
7	Бэлтгэгч, үйлчлэгчийн малгай	ш	87		
8	Богино ханцуйтай даавуун халад, өмд	ш	107		
9	Даавуун халад	ш	60		
10	Хулдаасан хормогч	ш	81		
11	Даавуун нөмрөг	ш	13		
12	Зөөгчийн цамц	ш	8		
13	Зөөгчийн хантааз	ш	8		
14	Зөөгчийн юбка болон эр өмд	ш	8		
15	Ажлын фудболк	ш	20		
16	Ажлын өмд	ш	20		
17	Ажлын пүүз	хос	903		
18	Засварын ажилчдын хувцас	хос	60		

Багц 6: Ахуй хэрэглэл

1	Цагаан хэрэглэл	хос	998	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд
2	Нимгэн оймс	хос	1700		
3	Ванны алчуур	ш	966		
4	Гарын алчуур	ш	3838		

5	Углааш усны	хос	170			
Багц 7: Хамгаалах хэрэгсэл						
1	Дуулганы бүрээс	ш	420	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	
2	Өвдөг, тохойны хамгаалалт	ш	420			
3	Агсамж	ш	420			
Багц 8: Майхан						
1	5*9 acar	ком	30	Налайх дүүрэг дэх ЗХ-ний 310-р ангийн хүнсний агуулах	Гэрээнд заасан хугацаанд	

## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

**[Захиалагч байгууллагын нэр]-д**

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.<sup>1</sup>
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг:**

<sup>1</sup> Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

Маягт 2      Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс <sup>2</sup>	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх <sup>3</sup>
1										Тийм/Үгүй
2										
...										
							Тендерийн нийт үнэ			

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг, байгууллагын  
тамга, тэмдэг]:

<sup>2</sup> ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

<sup>3</sup> Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3      Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4      Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6

**Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.		
2.		
3.		
4.		
5.		

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, too хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албан дээрээс нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацаа;
  - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- Гэрээний тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
  - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
  - 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
  - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
  - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
- ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ**
- Бараа нийлүүлэх
- 2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
- 2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
- 2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
- 2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
- 2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
- Бараа нийлүүлэх газар
- Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах

- |                           |   |
|---------------------------|---|
|                           | 2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:   |
|                           | 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;   |
|                           | 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.   |
|                           | 2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.   |
|                           | 2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.   |
| Барааг хүлээлгэн өгөх     | 2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.  |
|                           | 2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.   |
| Барааны гарал үүслийн улс | 2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.   |
|                           | 2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.  |
| Баглаа боодол             | 2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.   |
|                           | 2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.   |
|                           | 2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө.   |
| Худалдааны нөхцөл         | 2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.  |
|                           | 2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарыг дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.  |
| Гүйцэтгэлийн баталгаа     | 2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
|                           | 2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:  |

- 2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
- 2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
- 2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

#### **ГУРАВ. ЗАХИАЛАГЧ**

- |                    |   |
|--------------------|---|
| Барааг хүлээн авах | 3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.   |
| Шалгалт, туршилт   | <ul style="list-style-type: none"> <li>3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</li> <li>3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</li> <li>3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</li> <li>3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдлой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</li> <li>3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</li> </ul> |
| Гэрээний үнэ       | <ul style="list-style-type: none"> <li>3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</li> <li>3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</li> </ul>   |
| Төлбөр төлөх       | <ul style="list-style-type: none"> <li>3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</li> <li>3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</li> <li>3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</li> <li>3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</li> </ul>   |

- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

#### **ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**

Захиалагчийн хүлээх эрсдэл	<p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <ul style="list-style-type: none"> <li>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</li> <li>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</li> </ul>
Даатгал	<p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p>
Доголдол	<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
Чанарын баталгаа	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p>

- |   |  |
|---|--|
| <p>Алданги</p> <p>Оюуны өмчийн эрх зөрчих</p> <p>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</p> <p>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</p> | <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p> <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> |
|---|--|

**ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ**

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй: 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй; 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон; 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон. 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй. 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залиах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон. 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно. 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй. 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл	<b>ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</b>
Төлөөлөгч	6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана. 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна. 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ. 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
Туслан гүйцэтгэгч	6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална. 6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал
Нууцлал	

- зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
- Мэдэгдэл 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9-д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсандаа тооцно:
- 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
  - 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:
- 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;
  - 6.15.2. үнийн тохируулга хийсэн.
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрлөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- Маргаан шийдвэрлэх

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.5.</b>	Бараа нийлүүлэх газар: <b>[Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрын хаяг, байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих]</b>
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: <b>[Огноо бичих]</b> Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: <b>[Огноо бичих эсхүл нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]</b>
<b>ГЕН 2.10.</b>	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:

	<p>[Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих]          Бараанд холбогдох баримт бичиг: [бараанд холбогдох ямар баримт бичгүүдийг хүлээлгэж өгөх талаар бичих]          Угсралт, суурилуулах: [ямар барааг юунд, хэрхэн угсарч, суурилуулах гэх мэт.]</p>
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:  [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих.]  [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих]  Баглаа, боодлын шаардлага:  <b>Жишээ нь:</b>  [Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]</p>
ГЕН 2.17.	<p>Худалдааны нөхцөл:  [Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 20.6-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]</p>
ГЕН 3.8.	<p>Үнийн тохируулга хийх аргачлал:  “Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томьёог ашиглан тохируулна:  <math display="block">\Delta P = P_0 \left( a + b \frac{L_1}{L_0} + c \frac{M_1}{M_0} \right) - P_0</math></p> <p>Үүнд:  <math>\Delta P</math>-нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ  <math>P_0</math>-гэрээний үндсэн үнэ;  a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захирагааны зардлын тогтмол дүн.  Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;  b -гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;  c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;  <math>L_0</math>-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;  <math>L_0, L_1</math> -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;  <math>M_1, M_0</math> -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.  [Захиалагч a, b, c илтгэлциүүрүүдийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Энэ гурван илтгэлциүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.]  Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.  Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.  Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих]<sup>4</sup> долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).  Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд:  1. Гэрээний суурь үнэ [тоо бичих]<sup>5</sup> хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна.</p>

<sup>4</sup>Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.

<sup>5</sup>Арван таван (15) хувийг зүй зохистой хэмжээ гэж үзнэ.

	<p>2. Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үнийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно.</p> <p>Гэрээний үнийн /P0/ валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, запруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна.</p>
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр]</p> <p>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]</p>
ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]</p>
ГЕН 4.10.	<p>Баталгаат хугацаа:</p> <p>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]</p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа шаардана/ шаардахгүй]</p> <p>Чанарын баталгаа шаардах бол,</p> <p>Чанарын баталгааны дүн: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар бичих]</p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: [“Тийм”, “Үгүй” гэдгээс сонгох]</p> <p>Алдангийн хувь: [Хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</p>
ГЕН 4.18.	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: [“Тийм”, “Үгүй” гэдгээс сонгох]</p> <p>Алдангийн хувь: [Хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</p>

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Техникийн тодорхойлолт;
  - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_